МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26 75 33,
Цахим шуудан: info@mojha.gov.mn,
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2023.11.24 № 1/5980

танай 2023.11.08-ны № 03/2855-т

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД
Х.БУЛГАНТУЯА ТАНАА

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан "Мэргэжлээс шалтгаалсан өвчний жагсаалт, хувь, хугацааг батлах тухай" 2023 оны А/152, А/388 дугаар тушаалыг Захиргааны ерөнхий хуулийн дагуу хянан үзээд захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн ...6478... дугаарт бүртгэж хүргүүлэв.

Б.ЭНХБАЯР

151605?69

Doc.yam a5.2023

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд 2023 оны 11 сарын 24-ны өдрийн 6478 дугаарт бүртгэв.

# ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2023 оны 11 дугаар сарын 07-ны өдөр | Дугаар А/162 А/388 | Улаанбаатар хот

Мэргэжлээс шалтгаалсан өвчний жагсаалт, хувь, хугацааг батлах тухай

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1.“Мэргэжлээс шалтгаалсан өвчний жагсаалт, хувь, хугацаа”-г хавсралтаар баталсугай.

2.Энэ тушаалыг мөрдөж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газарт үүрэг болгосугай.

3.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Батжаргал/, Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газар /А.Өнөржаргал/-д тус тус даалгасугай.

4.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан “Даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтооход баримтлах өвчний жагсаалт, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хэмжээ, хугацааг шинэчлэн батлах тухай” Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/758, А/197 дугаар хамтарсан тушаалын 2 дугаар хавсралтыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчингүй болсонд тооцсугай.

5.Энэхүү тушаалыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД Х.БУЛГАНТУЯА

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД С.ЧИНЗОРИГ

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ ТБАГҮҮГ
ХУУЛБАР ҮНЭН
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА
Гарын үсэг:
2023 оны 11 сарын 08 өдөр

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын 2023 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн А/152, А/358 дугаар хамтарсан тушаалын хавсралт

# МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ ЖАГСААЛТ, ХУВЬ, ХУГАЦАА

| № | Өвчний нэр | Үе шат | Өвчний код | Хувь хэмжээ | Хугацаа | Хөдөлмөрийн нөхцөл солих |
|---|---|---|---|---|---|---|
| **1.Мэргэжлээс шалтгаалсан амьсгалын замын эмгэг** | | | | | | |
| Уушги тоосжих өвчин | | | | | | |
| 1.1 | Антракоз /антракосиликоз/ | Уушги тоосжих өвчин I үе | J60 | 30-40 | 1 жил | Хөдөлмөрийн нөхцөл солих |
| | Асбестоз | | J61 | | | |
| | Силикоз | | J62 | | | |
| | Сидероз, Цементоз | | J63 | | | |
| | Пневмокaниоз /холимог тоосоор үүсгэгдсэн/ | | J64 | | | |
| | Силикотуберкулёз | | J65 | | | |
| | Биссиноз | | J66 | | | |
| 1.2 | Антракоз /антракосиликоз/ | а/ Уушги тоосжих өвчин I үе, Амьсгалын дутагдал I зэрэг /Рентген зурагт ОУ-ын ILO ангилалаар жижиг сүүдэр тархалт 1/1/ | J60 | 41-50 | 1 жил | Хөдөлмөрийн нөхцөл солих |
| | Асбестоз | | J61 | | | |
| | Силикоз | | J62 | | | |
| | Сидероз, Цементоз | | J63 | | | |
| | Пневмокaниоз /холимог тоосоор үүсгэгдсэн/ | б/ Уушги тоосжих өвчин I үе, Амьсгалын дутагдал I зэрэг /Рентген зурагт ОУ-ын ILO ангилалаар жижиг сүүдэр тархалт 1/1, /1/2/ | J64 | 51-59 | 1 жил | |
| | Силикотуберкулёз | | J65 | | | |
| | Биссиноз | | J66 | | | |
| 1.3 | Антракоз /антракосиликоз/ | Уушги тоосжих өвчин II үе, Амьсгалын дутагдал I-II зэрэг, уушги тэлэгдэл, уушги зүрхний архаг дутагдал I үе, ээнэгшилтэй үе, хавсарсан сүрьеэ Рентген зураг: ОУ-ын хөдөлмөрийн байгууллагын ILO ангилалаар жижиг сүүдэр+том сүүдэр, А категори+плеврийн зузаарал, Тархалт:2/1, 2/2, 2/3 | J60 | 60-69 | 1 жил | Хөдөлмөрийн нөхцөл солих |
| | Асбестоз | | J61 | | | |
| | Силикоз | | J62 | | | |
| | Сидероз, Цементоз | | J63 | | | |
| | Пневмокaниоз /холимог тоосоор үүсгэгдсэн/ | | J64 | | | |
| | Силикотуберкулёз | | J65 | | | |
| | Биссиноз | | J66 | | | |

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам тбагүүг
ХУУЛБАР ҮНЭН
Төрийн захиргааны удирдлагын газрын дарга
Гарын үсэг
2023 он 11 сар 08 өдөр

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 1.4 | Антракоз /антракосиликоз/ | Уушги тоосжих өвчин III үе, Амьсгалын дутагдал II зэрэг, уушги тэлэгдэл, уушги зүрхний архаг дутагдал II үе, ээнэгшилээ алдсан үе, зүрхний архаг дутагдал С үе, сүрьеэ, гялтангийн наалдац, гялтангийн зузааралт Рентген зурагт: ОУ-ын хөдөлмөрийн байгууллагын ILO ангилалаар: жижиг сүүдэр+том сүүдэр В категори+плеврийн зузаарал, Тархалт: 3/1,3/2 | J60 | 70-79 | 1 жил | Хөдөлмөрийн нөхцөл солих |
| | Асбестоз | | J61 | | | |
| | Силикоз | | J62 | | | |
| | Сидероз, Цементоз | | J63 | | | |
| | Пневмоканиоз /холимог тоосоор үүсгэгдсэн/ | | J64 | | | |
| | Силикотуберкулёз | | J65 | | | |
| | Биссиноз | | J66 | | | |
| 1.5 | Антракоз /антракосиликоз/ | Уушги тоосжих өвчин III үе, Амьсгалын дутагдал III зэрэг, уушги тэлэгдэл, уушги зүрхний архаг дутагдалII-III үе, ээнэгшилээ алдсан үе, зүрхний архаг дутагдал D үе, сүрьеэ, гялтангийн наалдац, гялтангийн зузааралт Рентген зурагт: ОУ-ын хөдөлмөрийн байгууллагын ILO ангилалаар: жижиг сүүдэр+том сүүдэр С категори+плеврийн зузаарал, Тархалт: 3/3, 3/3+ | J60 | 80-100 | 1 жил | Хөдөлмөрийн нөхцөл солих |
| | Асбестоз | | J61 | | | |
| | Силикоз | | J62 | | | |
| | Сидероз, Цементоз | | J63 | | | |
| | Пневмоканиоз /холимог тоосоор үүсгэгдсэн/ | | J64 | | | |
| | Силикотуберкулёз | | J65 | | | |
| | Биссиноз | | J66 | | | |
| Тоосжилтын болон хордлогын шалтгаант гуурсан хоолойн архаг үрэвсэл | | | | | | |
| 1.6 | Тоосжилтын болон хордлогын шалтгаант гуурсан хоолойн архаг үрэвсэл | Тоосжилтын болон хордлогын шалтгаант гуурсан хоолойн архаг үрэвсэл хүндрэлгүй | J68 | 20 | 1 жил | Хөдөлмөрийн нөхцөл солих |
| 1.7 | Тоосжилтын болон хордлогын шалтгаант гуурсан хоолойн архаг үрэвсэл | Тоосжилтын болон хордлогын шалтгаант гуурсан хоолойн архаг үрэвсэл, Амьсгалын дутагдал I зэрэг | J68 | 30-55 | 1 жил | |
| 1.8 | | Тоосжилтын болон хордлогын шалтгаант гуурсан хоолойн архаг үрэвсэл, Амьсгалын дутагдал I зэрэг, Уушги тэлэгдэл | J68 | 56-69 | 2 жил | |
| 1.9 | | а/ Тоосжилтын болон хордлогын шалтгаант гуурсан хоолойн архаг үрэвсэл, Амьсгалын дутагдал I-II зэрэг, Уушги тэлэгдэл, уушгин зүрхний архаг дутагдал I үе, ээнэгшилтэй үе зүрхний архаг дутагдал С үе | J68 | 70-79 | 1 жил | |
| | | б/ Тоосжилтын болон хордлогын шалтгаант гуурсан хоолойн архаг үрэвсэл, Амьсгалын дутагдал II-III зэрэг, Уушги тэлэгдэл, уушги зүрхний архаг дутагдал II-III үе, ээнэгшлээ алдсан үе, зүрхний архаг дутагдал D үе | J68 | 80-100 | 1 жил | |
| 1.10 | Тоосжилт, харшил, хордлогын шалтгаант багтраа | а/ Тоосжилт, харшил, хордлогын шалтгаант багтраа хөнгөн зэрэг | J68.4 | 20 | 1 жил | Хөдөлмөрийн нөхцөл солих |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | б/ Тоосжилт, харшил хордлогын шалтгаант багтраа дунд зэрэг | | J68.4 | 30-40 | 1 жил | |
| 1.11 | | а/ Тоосжилт, харшил, хордлогын шалтгаант багтраа дунд зэрэг, амьсгалын дутагдал I зэрэг | | J68.4 | 41-50 | 2 жил | |
| | | б/ Тоосжилт, харшил, хордлогын шалтгаант багтраа дунд зэрэг, амьсгалын дутагдал II зэрэг, уушги зүрхний архаг дутагдал I үе, ээнэгшилтэй үе, зүрхний архаг дутагдал В үе | | J68.4 | 51-69 | 1 жил | |
| 1.12 | | Тоосжилт, харшил, хордлогын шалтгаант багтраа хүнд зэрэг, амьсгалын дутагдал II-III зэрэг, уушги зүрхний архаг дутагдал II үе, ээнэгшлээ алдсан үе, зүрхний архаг дутагдал C, D үе | | J68.4 | 70-80 | 1 жил | |
| **2. Мэргэжлээс шалтгаалсан хордлого** | | | | | | | |
| № | Өвчний нэр | Ерөнхий шинж тэмдэг | Үе шат | Өвчний код | Хувь хэмжээ | Хугацаа | Хөдөл мөрийн нөхцөл солих |
| Химийн бодисын архаг хордлогын улмаас үүсэх эмгэг | | | | | | | |
| 2.1 | Хүнд металлын хордлого /хар тугалга, хүнцэл, мөнгөн ус, хром, кадми, зэс, цайр, цагаан тугалга, берилли тэдгээрийн нэгдлүүд, бусад металлууд/ | а/ Мэдрэлийн хам шинж /Энцефалопати, полиневрит/ б/ Бөөрний гэмтлийн хам шинж /түүдгэн-цэр, сувганцрын үхжилт үрэвсэл, бөөрний архаг дутагдал/ в/ Хоол боловс-руулах замын архаг хямрал /диспепси, бага шимэгдэлтийн хам шинж, гэдэсний | а/ Хөнгөн үе (буйл хөөж хөхөвтөр болох, амны хөндий шархлах, аманд металл амтагдах, хоолой хорсох, хуурай ханиах, дотор муухайрах, бөөлжих, металлын халууралт, шинжилгээнд ретикуло-цитоз 25% хүртэл ихсэх, цус болон биологийн материалд тухайн хордсон металл илрэх) | T56 | 30-40 | 1 жил | Хөдөлмөрийн нөхцөл солих |
| | | | б/ Дунд үе (Захын мэдрэлийн эмгэгүүд, цус багадалт, толгой эр-гэх, толгой өвдөх, дотор муухайрах, шүд сулрах, сэтгэлээр унах, хараа муудах, амьсгалын замын үрэвсэл, арьсны үрэвсэл, шинжил-гээнд ретикулоцитоз 30% хүртэл ихсэх, цус болон биологийн мате-риалд тухайн хордсон металл илрэх) | T56 | 41-55 | 1 жил | |
| | | | в/ Хүндэвтэр үе (Нейропати, бөөрний түүдгэнцрийн болон сувганцрын гэмтэл, буйланд хар тугалганы хүрээ үүсэх, хамрын салст, ходоод, гэдэс, зүрх судасны системийн өвчлөл, | T56 | 56-69 | 1 жил | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | хатгаа шинж/ г/ Арьсны үрэвсэл, гиперпигментаци, ширшил, хатингаршил, салстын харлалт/ д/ Нөхөн үржихүйн эмгэгүүд /үргүйдэл зулбалт, тератоген нөлөөлөл/ Анхааруулга: Тухайн хордсон химийн бодисын ХАЛМ /хор аюулын лавлагаа мэдээлэл/-ийг заавал харьцуулж үзнэ | мэдрэл, сэтгэ-цийн өөрчлөлтүүд, шинжилгээнд ретикулоцитоз 40% хүртэл ихсэх, цус болон биологийн материалд тухайн хордсон металл зөвшөөрөг-дөх дээд хэмжээнээс өндөр байх) | | | | |
| | | | г/ Хүнд үе (Нейропати, бөөрний түүдгэнцрийн болон сувганцрын гэмтэл, үжлийн гаралтай неф-ропати, арьсны дерматит, хордло-гын шалтгаант энцефалопати, тэнэгрэлийн шинжүүд, бусад эрхт-нүүдийн дагалдах эмгэгүүд, шинжилгээнд ретикулоцитоз 40%-с дээш ихсэх, цус болон биологийн материалд тухайн хордсон металл зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс өндөр байх) | T56 | 70-90 | 1 жил | |
| 2.2 | Идэмхий бодисын хордлого /фенол, фенолын уламжлалууд, бусад идэмхий органик бодисууд, идэмхий хүчил, хүчил тест нэгдлүүд, идэмхий шүлт, шүлт тест нэгдлүүд / | а/ Арьс, салстын эмгэг өөрчлөлтүүд, арьсны үрэвсэл, гиперпигментаци, ширшил, хатингаршил, салстын харлалт/ б/ Амьсгалын эрхтэний хямрал в/ Хоол | а/ Хөнгөн үе (Арьсны загатнаа, уушги болон гуурсан хоолойн үрэвсэл, зүрх судас, цусны тогтолцооны өөрчлөлтүүд, мэдрэл, хоол боловсруулах эрхтэн тогтолцооны архаг эмгэгүүд, цус болон биологийн материалд тухайн хордсон идэмхий бодис илрэх) | T54 | 30-40 | 1 жил | Хөдөлмөрийн нөхцөл солих |
| | | | б/ Дунд үе (Дээрх шинжүүд дээр нэмэгдээд арьсны архаг үрэвсэл, тууралт, амьсгал бачуурах, боогдох, амьсгалын дутагдлын шинж илрэх, тураал, шүд суларч буйл үрэвсэх, цус гоожих, ходоод гэдэсний шархлаа | T54 | 41-55 | 1 жил | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | боловсруулах замын архаг хямрал /диспепси, бага шимэгдэлтийн хам шинж, гэдэсний хаттаа шинж/ Анхааруулга: Тухайн хордсон химийн бодисын ХАЛМ /хор аюулын лавлагаа мэдээлэл/-ийг заавал харьцуулж үзнэ | үүсэх, цус болон биологийн материалд тухайн хордсон идэмхий бодис илрэх) | | | | |
| | | | в/ Хүндэвтэр үе (Арьсны гиперпигментаци, арьс салсты хар-лалт, ширшил, хашингаршил, ууш-гины пневмосклероз, хордлогын шалтгаант энцефалопати, цус бо-лон биологийн материалд тухайн хордсон идэмхий бодис зөвшөөрөг-дөх дээд хэмжээнээс өндөр байх) | T54 | 56-69 | 1 жил | |
| | | | г/ Хүнд үе (Олон эрхтний дутмагшил, бодисын солилцооны түгээмэл хямрал, энцефалопати, цусархаг хам шинж, шээсэнд уураг, эпител, улаан эс, чөлөөт гемог-лобин илэрнэ, цус болон биологийн материалд тухайн хордсон идэмхий бодис зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс өндөр байх) | T54 | 70-80 | 1 жил | |
| Ароматик бодисуудын хордлого | | | | | | | |
| 2.3 | Ханасан ба үнэрт устөрөгчийн галогены уламжлалын хордлого /тетрахлорт нүүрстөрөгч, хлороформ, трихлорэтилен, тетрахлорэтилен, дихлорметан, хлорфторт нүүрстөрөгч, бусад ханасан нүүрстөрөгчийн галоген, формальдегид/ | а/ Тератоген нөлөө-лөл, б/ Генийн мутаци в/ Хавдар г/ Мэдрэл, хоол боловсруулах замын хямрал д/ Зүрх судасны тогтолцооны өөрчлөлтүүд е/ Арьс, салстын өөрчлөлтүүд Анхааруулга: Тухайн | а/ Хөнгөн үе (Ядрах сульдах, толгой өвдөх, нойр муудах, аманд муухай амтагдах, хоолой хатах, буйлаас цус гарах, амьсгаадах, мэдрэл, хоол боловсруулах эрхтэн, зүрх судасны тогтолцооны өөрчлөл-түүд, цус болон биологийн мате-риалд тухайн хордсон ароматик бодис илрэх) | T53 | 30-40 | 1 жил | Хөдөлмөрийн нөхцөл солих |
| | | | б/ Дунд үе (Дээрх шинжүүд дээр нэмэгдээд олон эрхтний хавсарсан архаг өөрчлөлтүүд илрэх цус болон биологийн материалд тухайн хордсон ароматик бодис илрэх) | T53 | 41-55 | 1 жил | |
| | | | в/ Хүндэвтэр үе (Арьсны архаг үрэвсэл, тууралт, цусны системийн өөрчлөлтүүд, анеми, зүрх судас, ходоод гэдэс, цуллаг эрхтнүүдийн үйл ажиллагааны архаг дутмагшил, | T53 | 56-69 | 1 жил | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | хордсон химийн бодисын ХАЛМ /хор аюулын лавлагаа мэдээлэл/-ийг заавал харьцуулж үзнэ | мэдрэл, сэтгэцийн хямрал, поли-невропати энцефалопати, цус бо-лон биологийн материалд тухайн хордсон ароматик бодис зөвшөө-рөгдөх дээд хэмжээнээс өндөр байх) | | | | |
| | | | г/ Хүнд үе (Элэг бөөр, зүрх судас олон эрхтэн хавсарсан архаг дутагдал, цусны эсүүдийн гүнзгий өөрчлөлт, мэдрэл, сэтгэцийн хямрал, хордлогын шалтгаант энцефалопати, ком, бодисын солилцооны түгээмэл хямрал, хүнд хэлбэрийн арьсны эмгэгүүд, цус болон биологийн материалд тухайн хордсон ароматик бодис зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс өндөр байх) | T53 | 70-85 | 1 жил | |
| Цочроогч, боогдуулагч бодис /хий, уур/-ын хордлого | | | | | | | |
| 2.4 | Хий ба ууршимтгай цочроогч, боогдуу-лагч бодисуудын хордлого /азотын исэл, хүхрийн давхар исэл, аммиак, нулимс асгаруулагч хий, хлор, фтор, фторт устөрөгч, хүхэрт устөрөгч, нүүрсхүч-лийн давхар исэл, бусад хий, утаа, уур/ | а/ Амьсгалын эрхтэний хямрал б/ Арьс, салстын цочролын хам шинжүүд в/ Мэдрэлийн хам шинж /уналт таталт, булчин сулрах/ Анхааруулга: Тухайн хордсон химийн бодисын ХАЛМ /хор аюулын лавлагаа мэдээлэл/-ийг заавал харьцуулж үзнэ | | а/ Хөнгөн үе (Амьсгалын дээд зам, арьс, салстын цочролын шинжүүд, хуурай ханиах, хоолой сөөх, хамар залгиур хуурайших, хорсох, цус болон биологийн материалд тухайн хордсон цочроогч, боогдуулагч бодис илрэх) | T59 | 30-40 | 1 жил | Хөдөлмөрийн нөхцөл солих |
| | | | | б/ Дунд үе (Риноларинг-фарингит, трахеобронхит, зүрх судасны архаг өвчнүүд, арьсны загатнаа, ходоод гэдэсний үрэвсэл цус болон биологийн материалд тухайн хордсон цочроогч, боогдуулагч бодис илрэх) | T59 | 41-55 | 1 жил | |
| | | | | в/ Хүндэвтэр үе (Хордлогын шалтгаант бронхит, багтраа, пневмосклероз, амьсгалын дутаг-дал, цусны системийн өөрчлөлтүүд, мэдрэлийн хэсэгчилсэн голомтот шинжүүд, элэг, бөөрний архаг үрэв-сэл цус болон биологийн мате-риалд тухайн хордсон цочроогч, боогдуулагч бодис зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс өндөр байх) | T59 | 56-69 | 1 жил | |
| | | | | г/ Хүнд үе (Энцефалопати, олон эрхтний дутмагшил, бодисын | T59 | 70-85 | 1 жил | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | солилцооны түгээмэл хямрал, амьсгал, зүрх судасны үйл ажил-лагаа алдагдаж төв мэдрэлийн систем гипоксид орох, уушги, тар-хины хавдар илэрч болно цус болон биологийн материалд тухайн хорд-сон цочроогч, боогдуулагч бодис зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс өндөр байх) | | | | |
| Пестицитын хордлого | | | | | | | |
| 2.5 | Пестицитын хордлого /Органик фосфат ба карбамат, хлорорга-ник, фосфор органик агуулсан шавж уст-гагчууд, гербицид, фунгицид, роденти-цид, бусад дестицитүүд/ | а/ Мэдрэл сульдлын хам шинж<br>б/ Дотоод шүүрлийн өөрчлөлт<br>в/ Цусны эмгэг өөрчлөлт<br>Анхааруулга: Тухайн хордсон химийн бодисын ХАЛМ /хор аюулын лавлагаа мэдээлэл/-ийг заавал харьцуулж үзнэ | а/ Хөнгөн үе (Толгой эргэх, өвдөх, нойр муудах, ядрах, арьс загатнах, хоол боловсруулах эрхтэн, зүрх судасны хямрал, цусны элементүүдийн өөрчлөлтүүд, цус болон биологийн материалд пестицид илрэх) | Т60 | 30-40 | 1 жил | Хөдөлмөрийн нөхцөл солих |
| | | | б/ Дунд үе (Дотор муухайрах, аманд төмөр амтагдах, шүлс гоожих, хоолонд дургүй болох, хөлрөх, хүүхэн хараан гэрлийн урвал сулрах, элэг, бөөрний архаг үрэвсэл, арьсны загатнаа, цусны элементүүдийн өөрчлөлтүүд, цус болон биологийн материалд пестицид илрэх) | Т60 | 41-55 | 1 жил | |
| | | | в/ Хүндэвтэр үе (Халуурах, бөөлжих, булчингаар өвдөх, полиневрит, айдас түгшүүртэй болох сандрах, хүүхэн хараа нарийсах, элэгний хатуурал, дотоод шүүрлийн булчирхайн өөрчлөлтүүд, амьсгалын дутагдал, багтраа, цусны элементүүдийн өөрчлөлтүүд, цус болон биологийн материалд пестицид зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс өндөр байх) | Т60 | 56-69 | 1 жил | |
| | | | г/ Хүнд үе (гэдэс хүчтэй базалж өвдөх, гүйлгэх, ухаан муудах, хий юм харах, шизофрени төст шинж, эпилепси төст уналт, энцефалопатийн шинж илрэх, элэгний хатуурлийн эцсийн шат, бөөрний дутагдал, зүрх судасны | Т60 | 70-90 | 1 жил | |

ТУ3684 9132155 119277737

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | дутагдал цус болон биологийн материалд пестицид зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс өндөр байх) | | | | |
| Органик бус бодисын хордлого | | | | | | | |
| 2.6 | Бусад органик бус бодисын хордлого /марганц тэдгээрийн нэгдлүүд, устөрөгчийн цианид, бусад органик бус нэгдлүүд/ | а/ Мэдрэлийн хам шинж /энцефалопати, полиневрит/<br>б/ Бөөрний гэмтлийн хам шинж /түүдгэнцэр, сувганцрын үрэвсэл, бөөрний дутагдал/<br>в/ Хоол боловсруулах замын хямрал/<br>г/ Арьсны өөрчлөлт<br><br>Анхааруулга: Тухайн хордсон химийн бодисын ХАЛМ /хор аюулын лавлагаа мэдээлэл/-ийг заавал харьцуулж үзнэ | а/ Хөнгөн үе (Арьсны өнгө хөхрөх, булчингийн хүч сулрах, нүд бүлтийх, шөрмөсний рефлекс сулрах, арьсны зураглал тодрох хоол боловсруулах эрхтэн, зүрх судасны өвчнүүд, цус болон биологийн материалд тухайн хордсон органик бус бодис илрэх) | T57 | 30-40 | 1 жил | Хөдөлмөрийн нөхцөл солих |
| | | | б/ Дунд үе (Нүүрний булчингийн хөдөлгөөн буурах, булчингийн тонус ихсэх, харц гөлийх, хөдөлгөөн удаашрах, тэнцвэр алдах, арьсны тэжээллэгийн өөрчлөлтүүд, цус болон биологийн материалд тухайн хордсон органик бус бодис илрэх) | T57 | 41-55 | 1 жил | |
| | | | в/ Хүндэвтэр үе (Хордлогын шалтгаант энцефалопати, поли-невропати, цус багадалт, бамбай, бөөрний дээд булчирхайн ду-тагдлын шинжүүд, нүүрний хувирал багасч баг өмссөн мэт болох, шөрмөсний рефлексүүд өндөрсч клонус илрэх, ходоод гэдэсний шархлаа, элэгний хатуурал, цусны эсүүдийн гүнзгий өөрчлөлтүүд, тархины хэсэгчилсэн голомтот шинжүүд, бодисын солилцооны хүчилшилт, цус болон биологийн материалд тухайн хордсон органик бус бодис зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс өндөр байх) | T57 | 56-69 | 1 жил | |
| | | | г/ Хүнд үе (Паркинсоны хам шинж тод илрэхээс гадна олон эрхтэний хавсарсан дутмагшил, хорт хавдар, цус болон биологийн материалд тухайн хордсон органик бус бодис зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс өндөр байх) | T57 | 70-90 | 1 жил | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.7. | Нүүрстөрөгчийн дан ислийн хурц хордлогын үлдэц | Мэдрэлийн хам шинж /энцефалопати, полинейропати, паркинсон, саажилт/ Анхааруулга: Нүүрстөрөгчийн дан ислийн ХАЛМ /хор аюулын лавлагаа мэдээлэл/-ийг заавал харьцуулж үзнэ | а/ Хөнгөн үе (Толгой өвдөх, толгой эргэх, ядрах, тэнцвэр алдагдах, гуйвах, цусанд карбоксигемоглобин 10-20% болох) | Т58 | 30-40 | 1 жил | Хөдөлмөрийн нөхцөл солих |
| | | | б/ Дунд үе (Хөдөлгөөний эвсэл алдагдах, хөдөлгөөн сулрах, ухаан алдах, унтамхай болох, нүүрээр ягаан, улаан толбо гарах, бөөлжих нь нэмэгдэх, нүүр, их биеийн булчин жирвэгнэх, цусанд карбоксигемоглобин 21-30% болох) | Т58 | 41-55 | 1 жил | |
| | | | в/ Хүндэвтэр үе (Дээрх шинжүүд хүндрэх, ухааангүй болох, хожуу үеийн энцефалопати, цусанд карбоксигемоглобин 31-35% болох) | Т58 | 56-69 | 1 жил | |
| | | | г/ Хүнд үе (Танин мэдэхүйн гүйцэтгэл буурах, хожуу үеийн энцефалопати, полинейропати, паркинсон, саажилт, цусанп карбоксигемоглобин 36-40% болох) | Т58 | 70-79 | 2 жил | |
| | | | д/ Маш хүнд үе (Ухаан бүрэн алдаж комд орох, энцефалопати хүнд үе, мөчүүд хөхрөх, судасны цохилт 100-120 хүрэх, булчин хөших, чангарах, даралт буурах, таталт өгөх, цусанд карбоксигеиоглобин 41%-иас дээш болох) | Т58 | 80-90 | 1 жил | |
| Органик хүчлүүд ба түүний нэгдлүүд | | | | | | | |
| 2.8 | Органик уусгагчууд /шатахууны нэгдлүүд, бензин, бензины нэгдлүүд, толоул, ксилол, нафталинг-ликол, кетон, бусад органик уусгагчууд/ | а/ Мэдрэлийн хам шинж /энцефалопати/ б/ Бөөрний гэмтлийн хам шинж в/ Хоол боловсруулах замын хямрал/ г/ Зүрх, судасны өөрчлөлт Анхааруулга: Тухайн хордсон химийн бодисын ХАЛМ /хор аюулын лавлагаа мэдээлэл/-ийг заавал харьцуулж үзнэ | а/ Хөнгөн үе (Арьс салст хөхөлбөр болох, тэнцвэр алдагдах, шөрмөсний рефлекс өндөрсөх хоол боловсруулах, эрхтний хөнгөн хямрал, элэг бөөрний архаг үрэвсэл, уушги, гуурсан хоолой, арьс салстын үрэвсэл цус болон биологийн материалд тухайн хордсон бодис илрэх) | Т52 | 30-40 | 1 жил | Хөдөлмөрийн нөхцөл солих |
| | | | б/ Дунд үе (Дээрх шинжүүд дээр нэмээд мэдрэл, сульдал, тураал, цусны тогтолцооны өөрчлөлт ил-рэх, цус болон биологийн мате-риалд тухайн хордсон бодис илрэх) | Т52 | 41-55 | 1 жил | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | в/ Хүндэвтэр үе (Тремор, сонсгол буурах, анхаарал төвлөрөл буурч богино хугацааны ойн алдагдал, ходоод гэдэсний түгжрэл, сорви-жилтийн эмгэгүүд, тураал, арьс салстын архаг хүндрэлт өвчнүүд, цус болон биологийн материалд тухайн хордсон бодис зөвшөөрөг-дөх дээд хэмжээнээс өндөр байх) | T52 | 56-69 | 1 жил | |
| | | | г/ Хүнд үе (Тархины хүнд хэлбэрийн өөрчлөлт энцефалопати, уушгины хаван, бодисын солилцооны түгээ-мэл хямрал, олон эрхтний дутмаг-шил, цус болон биологийн мате-риалд тухайн хордсон бодис зөв-шөөрөгдөх дээд хэмжээнээс өндөр байх) | T52 | 70-90 | 1 жил | |
| **3. Мэргэжлээс шалтгаалсан арьс, харшлын өвчин** | | | | | | | |
| 3.1 | Мэргэжлээс шалтгаалсан хавьтал, харшлын дерматит | | Ажил, мэргэжилтэй холбоотой эм, химийн бодис, будах тослох материал, металл, нефтийн бүтээгдэхүүн, болон бусад бодисын нөлөөгөөр үүссэн хавьтал харшлын дерматит байнгын сэдрэлтэй | L23 | 30-50 | 1 жил | Хөдөлмөрийн нөхцөл солих |
| 3.2 | Мэргэжлээс шалтгаалсан энгийн хавьтлын цочролт дерматит | | а/ Ажил, мэргэжилтэй холбоотой хими, физик, биологи, механик цочроогч хүчин зүйлсийн нөлөөгөөр үүссэн энгийн хавьтлын цочролт дерматит жилд 3 ба түүнээс дээш удаа сэдрэл өгсөн | L24 | 20 | 1 жил | Хөдөлмөрийн нөхцөл солих |
| | | | б/ Ажил, мэргэжилтэй холбоотой хими, физик, биологи, механик цочроогч хүчин зүйлсийн нөлөөгөөр үүссэн энгийн хавьтлын цочролт дерматит байнгын сэдрэлтэй | L24 | 30-50 | 1 жил | |
| 3.3 | Мэргэжлээс шалтгаалсан хавьтал харшлын дерматит болон энгийн хавьтлын цочролт дерматит архагшиж хүндрэл үүссэн | | а/ Полиаллергийн хэлбэрт шилжсэн, эмчилгээнд засал авахгүй, эмийн эмчилгээ тохирохгүй болсон харшлын өвчин байнгын сэдрэлтэй, хүндрэл өгсөн | L23<br>L24 | 51-60 | 1 жил | Хөдөлмөрийн нөхцөл солих |
| | | | б/ Дархлааны тогтолцооны илэрхий өөрчлөлт үүссэн, харшлын байнгын сэдрэлтэй, хүндрэл өгсөн | L23<br>L24 | 61-70 | 1 жил | |
| **4. Мэргэжлээс шалтгаалсан нүдний өвчин** | | | | | | | |
| 4.1 | Мэргэжлээс шалтгаалсан зовхи салстын хурц болон архаг үрэвсэл /коньюктивит/, нулимс дамжуулах замын эмгэг | | | H10<br>H11<br>H04 | 20 | 1 жил | Хөдөлмөрийн нөхцөл солих |
| 4.2 | Мэргэжлээс шалтгаалсан эврэвчийн хурц болон архаг үрэвсэл, цагаа унах, | | а/ Хоёр нүдний илүү сайн харж байгаа нүд нь 0.1-0.3 хараатай /ДЭМБ тодорхойлолтоор дунд зэргийн сул хараатай/ | H17 | 50-69 | 2 жил | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | б/Зохих эмчилгээ хийлгэсний дараа тохирсон шилээр хоёр нүдний илүү сайн харж байгаа нүд 0.05-0.09 хараатай /ДЭМБ тодорхойлолтоор хүнд зэргийн сул хараатай/ | H17 | 70-89 | 1 жил | |
| | | в/ Зохих эмчилгээ хийлгэсний дараа тохирсон шилээр хоёр нүдний илүү сайн харж байгаа нүд 0.05-с доош хараатай /ДЭМБ тодорхойлолтоор сохор/ | H17 | 90-100 | Хугацаа гүй | |
| 4.3 | Мэргэжлээс шалтгаалсан нүдний болорын эмгэг /катаракта/ | Нэг нүдний хараа хэвийн буюу тохирсон шилээр 0.3 ба түүнээс дээш хараатай, нөгөө нүд 0.05-с доош хараатай | H26 | 50-69 | 2 жил | |
| 4.4 | Мэргэжлээс шалтгаалсан хараан ы мэдрэлийн үрэвсэл, болон хатингаршил | а/ Хоёр нүдний илүү сайн харж байгаа нүд нь 0.1-0.3 хараатай /ДЭМБ тодорхойлолтоор дунд зэргийн сул хараатай/ | H46 H47 | 50-69 | 2 жил | Хөдөлмөрийн нөхцөл солих |
| | | б/Зохих эмчилгээ хийлгэсний дараа тохирсон шилээр хоёр нүдний илүү сайн харж байгаа нүд 0.05-0.09 хараатай /ДЭМБ тодорхойлолтоор хүнд зэргийн сул хараатай/ | H46 H47 | 70-89 | 1 жил | |
| | | в/ Зохих эмчилгээ хийлгэсний дараа тохирсон шилээр хоёр нүдний илүү сайн харж байгаа нүд 0.05-с доош хараатай /ДЭМБ тодорхойлолтоор сохор/ | H46 H47 | 90-100 | Хугацаа гүй | |
| 4.5 | Мэргэжлээс шалтгаалсан нүдний даралт ихсэх эмгэг /хоёрдогч глаукома/ | а/ Хоёр нүдний илүү сайн харж байгаа нүд нь 0.1-0.3 хараатай /ДЭМБ тодорхойлолтоор дунд зэргийн сул хараатай/ эсвэл харах талбай 2 нүдэнд 40 градус хүртэл нарийссан /төвийн хараа нь хэвийн байж болно/ | H40 | 50-69 | 2 жил | Хөдөлмөрийн нөхцөл солих |
| | | б/Зохих эмчилгээ хийлгэсний дараа тохирсон шилээр хоёр нүдний илүү сайн харж байгаа нүд 0.05-0.09 хараатай /ДЭМБ тодорхойлолтоор хүнд зэргийн сул хараатай/ эсвэл харах талбай 2 нүдэнд 20 градус хүртэл нарийссан /төвийн хараа нь хэвийн байж болно/ | H40 | 70-89 | 1 жил | |
| | | в/ Зохих эмчилгээ хийлгэсний дараа тохирсон шилээр хоёр нүдний илүү сайн харж байгаа нүд 0.05-с доош хараатай /ДЭМБ тодорхойлолтоор сохор/ эсвэл харах талбай 2 нүдэнд 10 градус хүртэл нарийссан /төвийн хараа нь хэвийн байж болно/ | H40 | 90-100 | Хугацаа гүй | |
| 4.6 | Мэргэжлээс шалтгаалсан торовчийн эмгэг /миопия болон бусад/ | а/ Хоёр нүдний илүү сайн харж байгаа нүд нь 0.1-0.3 хараатай /ДЭМБ тодорхойлолтоор дунд зэргийн сул хараатай/ эсвэл харах талбай 2 нүдэнд 40 градус хүртэл нарийссан /төвийн хараа нь хэвийн байж болно/ | H35 H52 | 50-69 | 2 жил | Хөдөлмөрийн нөхцөл солих |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | б/Зохих эмчилгээ хийлгэсний дараа тохирсон шилээр хоёр нүдний илүү сайн харж байгаа нүд 0.05-0.09 хараатай /ДЭМБ тодорхойлолтоор хүнд зэргийн сул хараатай/ эсвэл харах талбай 2 нүдэнд 20 градус хүртэл нарийссан /төвийн хараа нь хэвийн байж болно/ | H35 H52 | 70-89 | 1 жил | |
| | | в/ Зохих эмчилгээ хийлгэсний дараа тохирсон шилээр хоёр нүдний илүү сайн харж байгаа нүд 0.05-с доош хараатай /ДЭМБ тодорхойлолтоор сохор/ эсвэл харах талбай 2 нүдэнд 10 градус хүртэл нарийссан /төвийн хараа нь хэвийн байж болно/ | H35 H52 | 90-100 | Хуга цаагүй | |
| **5. Мэргэжлээс шалтгаалсан мэдрэлийн өвчнүүд** | | | | | | |
| 5.1 | Хэсгийн, ерөнхий, хавсарсан доргионы өвчин | а/ I үе (дээд мөчний полиневропати, мэдрэхүй, вегетатив өөрчлөлт, дээд мөчний хялгасан судасны тонус алдагдал, ачаалалтай ажиллах буюу даарсан үед гар цайрах, шөнийн өвдөлт илрэх, хүйтний сорил) | T75 | 30-40 | 1 жил | Хөдөлмөрийн нөхцөл солих |
| | | б/II үе (дээд мөчинд өвдөлт мэдрэхүйн шинж байнга илрэх, дунд мэдрэлийн дарагдлын шинж, мэдрэхүйн алдагдал тод илэрч, вегатодистони астени, "Паля" шинж, гарын дулаан буурч, жижиг үений хэлбэр алдагдах, булчингийн хатингаршил, нурууны нугаламуудын остеоартроз, спондилопати үүсэх) | T75 | 41-69 | 1 жил | |
| | | в/III үе (судасны агшилт байнгын дахилттай болж, мэдрэхүйн тэжээлийн өөрчлөлт гүнзгий илрэх, мэдрэлийн ёзоор цочрол, дарагдлын хам шинж, Рейно шинж илрэх, гипоталамусын хямрал, ангиодистони хямрал, тархи бо-лон зүрхний хэм судсанд илрэх, хүнд үед дисцир-куляторный энцефалопатийн хам шинж, бэлгийн үйл ажиллагаа сулрах, доргионы мэдрэхүй буурах) | T75 | 70-80 | 1 жил | |
| 5.2 | Цахилгаан соронзон талбай, лазер, радио долгионы нөлөөллөөс үүсэн өвчин | а/ Хөнгөн үе (Вегетатив мэдрэлийн хямрал ихтэй астени, нойргүйдэл, захын мөчний салгалалт, хэт цочромтгой, зүрх судасны тогтолцооны хямрал) | W85 | 30-45 | 1 жил | Хөдөлмөрийн нөхцөл солих |
| | | б/ Дунд үе (Мэдрэлийн системийн голомтот шинжүүд, зүрх судасны дутагдлын хам шинж, энцефалопати, ой санамж эрс муудах, нүдний болор цайх, арьсны уян хатан чанар алдагдах, дерматит үүсэх, хумс хугарамтгай болох) | W85 | 46-69 | 1 жил | |
| | | в/ Хүнд үе (Хүнд хэлбэрийн астени, вазопати, диэнцефа-лопатийн хямрал, сэтгэл хөдлөл буурч | W85 | 70-80 | 1 жил | |

ТУ3894
0132155
119277787

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | уналт, бамбай булчирхайн хямралууд илэрсэн гипохромный анеми) | | | | |
| 5.3 | Нурууны спондилопати /остео-хондроз, спондилёз, ивэрхийн шалтгаант компрессионно-ише-мический синдром, хүзүү сээр, бүсэлхий, ууцны хэсгийн ради-кулопати/ дээд, доод мөчний мэдрэлийн язгуурын өвдөлт дарагдлын хам шинж | а/ Тогтмол биш өвдөх, үе үе хөдөлгөөн хязгаарлагдах, бадайрах, вегетатив өөрчлөлт илрэх | G54 | 20 | 1 жил | Хөдөлмөрийн нөхцөл солих |
| | | б/ Өвдөлтийн шинж жилд 2-3 удаа дахилттай, булчингийн чангарал, өвдөлт болон вегетатив өөрчлөлтүүд байнга илрэх | G54 | 30-55 | 1 жил | |
| | | в/ Язгуур мэдрүүлийн дарагдлын шинжтэй, булчингийн зангирал, нурууны муруйлттай, өвдөлт, рефлекс, мэдрэхүйн хүрээний түвшингийн өөрчлөлттэй | G54 | 56-69 | 1 жил | |
| | | г/ Мэс заслын эмчилгээний дараах язгуур мэдрэлийн гаралтай саатай, бага аарцгийн эрхтний хүнд зэргийн үйл ажиллагааны алдагдалтай, мэс засал хийх боломжгүй, олон нуруу нугаламыг хамарсан эмгэг | G54 | 70-80 | 1 жил | |
| **6. Мэргэжлээс шалтгаалсан чих, хамар, хоолойн өвчин** | | | | | | |
| 6.1 | Шуугианы нөлөөгөөр үүссэн сонсгол бууралт | а/ сонсгол бууралт II үе | H83.3 | 20 | 1 жил | Хөдөлмөрийн нөхцөл солих |
| | | б/ сонсгол бууралт III үе | H83.3 | 30-69 | 1 жил | |
| | | в/ сонсгол бууралт IV үе | H83.3 | 70-80 | 2 жил | |
| 6.2 | Мэргэжлээс шалтгаалсан өгүүлэх эрхтэний эмгэг | а/ Дууны хөвчийн үйл ажиллагааны алдагдалтай | J38 J38.0 | 20 | 1 жил | Хөдөлмөрийн нөхцөл солих |
| | | б/ Дууны хөвчийн хэсэгчилсэн саатай | J38 J38.0 | 30-59 | 1 жил | |
| | | в/ Дууны хөвчийн хоёр талын саатай | J38 J38.0 | 60-69 | 1 жил | |
| | | г/ Дууны хөвчийн хавдар | J38 J38.0 | 70-90 | 1 жил | |
| 6.3 | Мэргэжлээс шалгаалсан амьсгалын дээд замын эмгэг | а/ Хамар, залгиур, төвөнхийн архаг хатингаршилт үрэвсэл | J31 | 20 | 1 жил | Хөдөлмөрийн нөхцөл солих |
| | | б/ Хамрын таславчид цооролт үүссэн | J31 J34.8 | 30-69 | 1 жил | |
| | | в/ Мэргэжлээс шалтгаалсан амьсгалын дээд замын хавдар | J31 J34.8 | 70-90 | 1 жил | |
| **7. Мэргэжлээс шалтгаалсан туяаны өвчин** | | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 7.1 | Мэргэжлээс шалтгаалсан цацраг идэвхит бодис болон рентген туяанаас үүссэн туяаны өвчин | а/ I үе: Астеновегетатив хам шинжүүд, диспепси, ходоодны шүүрэл багасах, эрэгтэй хүнд импотенци, эмэгтэй хүнд өндгөвчний үйл ажиллагаа хямрах, захын цусанд лейкопени 3.0 хүртэл буурах, тромбоцитопени, нейтрофил эсийн хордлогын мөхлөгтэй, цусархаг хам шинж бага зэрэг илрэх | W88-91 | 30-40 | 1 жил | Хөдөлмөрийн нөхцөл солих |
| | | б/ II үе: Судасны дистони, астеновегетатив хам шинжүүд үс унах, хумсны өөрчлөлт, диэнцефалийн криз өгөх, богино хугацаанд ухаан алдах, бүх биеийн гипергидроз, пароксизмал тахикарди, бие чичрах, цус шүүрэмтгий болох, цусархаг хам шинжүүд, ходоод гэдэсний шүүрэл буурах, хордлогын гепатит, захын цусанд 2,5 г/л хүртэл буурах, нейтропени, лимфоцитопени 3 г/л хүртэл буурах, тромбоцитопени, нейтрофил эс хордлоыг мөхлөгтэй, цусны чөмөгний шинжилгээнд гипоплази илэрсэн | W88-91 | 41-69 | 1 жил | |
| | | в/ III-IV: цус төлжилт дарангуйлагдсан, мэдрэлийн тогтолцооны хүнд зэргийн өөрчлөлт их, байнгын нойргүйдэл, толгой эргэх, дотор муухайрах, ой тогтоолт буурах, цусархаг хам шинжүүд, салстат шархлаат некрозын өөрчлөлт, үс халцрах, дотоод шүүрлийн булчирхайн үйл ажиллагаа хямрах, захын цусанд лейкопени 1 г/л хүртэл буурах, нейтропени, лимфоцитопени 3 г/л хүртэл буурах, тромбоцитопени, гиперхромын цус багадалт, сепсис | W88-91 | 70-80 | 1 жил | |
| **8. Мэргэжлээс шалтгаалсан мэс заслын өвчин** | | | | | | |
| 8.1 | Мэргэжлээс шалтгаалсан доод мөч, хэвлий, аарцгийн эрхтний венийн бүдүүрэл | а/ C-1,2: өнгөц венийн судас өргөсөл<br>E-s: ажил мэргэжилтэй холбоотой<br>A-s,p,d: өнгөц, гүний, холбогч венийн судасны бүдүүрэл үүссэн<br>P-r: цусны буцах урсгал үүссэн | I83 | 20 | 1 жил | Хөдөлмөрийн нөхцөл солих |
| | | б/ C-1, 2, 3: өнгөц венийн судас өргөссөн, хавагнасан<br>E-s: ажил мэргэжилтэй холбоотой<br>A-s,p,d: өнгөц, гүний, холбогч венийн судасны бүдүүрэл үүссэн<br>P-r, o: цусны буцах урсгал үүссэн, хэсэгчилсэн бөглөрөл үүссэн | I83 | 30-55 | 2 жил | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | в/ С-1,2,3,4: өнгөц венийн судас өргөссөн, байнгын хаван, арьсны нөсөө<br>E-s: ажил мэргэжилтэй холбоотой<br>A-s,p,d: өнгөц, гүний, холбогч венийн судасны бүдүүрэл үүссэн,<br>Р-г, о: цусны буцах урсгал үүссэн, хэсэгчилсэн бөглөрөл, тромбоз, тромбофлебит үүссэн | I83 | 56-69 | 2 жил | |
| | | г/ С-1,2,3,4,5,6: өнгөц венийн судас өргөссөн, байнгын<br>хаван, арьсны нөсөө, шархлаа, үхжил<br>E-s: ажил мэргэжилтэй холбоотой<br>A-s,p,d: өнгөц, гүний, холбогч венийн судасны бүдүүрэл үүссэн<br>Р-г, о: цусны буцах урсгал үүссэн, хэсэгчилсэн бөглөрөл, тромбоз, тромбофлебит үүссэн | I83 | 70-80 | 1 жил | |
| 8.2 | Мэргэжлээс шалтгаалсан тохойн үений хэлбэр хөдөлгөөн алдагдах эмгэг | а/ 1-2 үений хөдөлгөөн хязгаарлагдсан<br>Үений далайц 10-30 градус болсон | М21.2 | 20 | 1 жил | Хөдөлмөрийн нөхцөл солих |
| | | б/ 1-2 үений хөдөлгөөн хязгаарлагдсан<br>Үений далайц 31-40 градус болсон | М21.2 | 30-55 | 2 жил | |
| | | в/ 3-4 үений хөдөлгөөн хязгаарлагдсан<br>Үений далайц 41-50 градус болсон | М21.2 | 56-69 | 2 жил | |
| | | г/ 3-4 үений хөдөлгөөн хязгаарлагдсан<br>Үений далайц 51-90 градус болсон | М21.2 | 70-80 | 1 жил | |
| 8.3 | Мэргэжлээс шалтгаалсан артерийн судасны олдмол нарийсал ба бөглөрөл | а/ I үе: Томоохон судсууд хэсэгчилсэн байдлаар нарий-<br>сах хүндрэлгүй | I74 | 20 | 1 жил | Хөдөлмөрийн нөхцөл солих |
| | | б/ I-II үе: Томоохон судсууд хэсэгчилсэн байдлаар нарий-<br>сах, бөглөрөх | I74 | 30-55 | 1 жил | |
| | | в/ I-II үе: Томоохон судсууд нилэнхүйдээ нарийсах, бөглө-<br>рөх, хурууны үзүүр үхжиж эхлэх | I74 | 56-69 | 1 жил | |
| | | г/ III үе: I, II үеийн өөрчлөлтүүд гүнзгийрч, гар болон хөлийн хуруу, шилбээр тайралт хийсэн | I74 | 70-85 | 1 жил | |
| 8.4 | Мэргэжлээс шалтгаалсан дээд мөчний бичил гэмтэл, давтагдсан ачааллаас үүссэн өвчнүүд / үений холбоосын өвчин, дээд | а/ мөр, бугалга, бугуйн үезр өвдөх, янгинах, хөдөлгөөний<br>далайц алдагдах, хавдах, улайх | М67.8 | 20 | 1 жил | Хөдөлмөрийн нөхцөл солих |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | мөчний мэдрүүлийн саа, шөрмөсний ба уутанцрын үрэвсэл/ | б/ дээрх өөрчлөлт дээр нэмэгдэж мөр, бугалга, гарын хатингарт саа, сарвууны саажил, хатингирал, мэдрэхүйн өөрчлөлт илрэх | M67.8 | 30-55 | 2 жил | |
| | | в/ дээрх өөрчлөлтүүд гүнзгийрч, хөдөлгөөн бүрэн хязгаарлагдах, эмгэг хугарал үүсэх | M67.8 | 56-69 | 2 жил | |
| 8.5 | Мэргэжлээс шалтгаалсан тавхай хавтгайрах эмгэг | а/ хөлийн шилбэ, тавхай, хурууны өвчнүүд булчин шөр-<br>мөсний чангарал, суналт | M21.4 | 20 | 1 жил | Хөдөлмөрийн нөхцөл солих |
| | | б/ хөлийн шилбэ, тавхай, хурууны өвчнүүд булчин шөр-<br>мөсний чангарал, суналт, яс ургалт | M21.4 | 30-55 | 2 жил | |
| | | в/ дээрх өөрчлөлтөөс гадна хөдөлгөөний үйл ажил-лагааны алдагдал III зэрэг | M21.4 | 56-69 | 2 жил | |
| | | г/ хөлийн тавхай хуруу тайрагдах, ясны үхжил болох /ос-<br>теонекроз/, эмгэг хугарал | M21.4 | 70-80 | 1 жил | |
| **9. Мэргэжлээс шалтгаалсан хавдар** | | | | | | |
| 9.1 | Дурангийн ажилбар, мэс засал, хими, туяа эмчилгээгээр бүрэн эмчлэгдсэн нэн эрт үе (Cancer in situ) болон эрт үеийн (I үе шат) хорт хавдрууд<br>(Дахин мэс засал болон өвөрмөц эмчилгээ хийгдэх шаардлагагүй нэн эрт үе, эрт үеийн хавдрууд хамаарна) | | Тухайн эрхтний хавдрын ICD кодоор ангилна | 50-69 | 3 хүртэл жил | Хөдөлмөрийн нөхцөл солих |
| 9.2 | Онош нь бүрэн батлагдсан II, III үе шатны хорт хавдрууд (Мэс засал, хими, туяа эсвэл хавсарсан эмчилгээ хийгдсэн хавдрууд)<br>(1. Дан мэс засал, хими, туяа эмчилгээ хийгдсэн II, III үе шатны хорт хавдрууд<br>2. Хавсарсан эмчилгээ хийгдсэн II, III үе шатны хорт хавдрууд хамаарна) | | | 70-79 | 5 хүртэл жил | |
| 9.3 | Онош нь бүрэн батлагдсан алсын болон ойрын эрхтэндээ үсэрхийлж IV үедээ орсон хорт хавдрууд | | | 100 | 5 хүртэл жил | |
| 9.4 | Хорт хавдрын үе шатнаас үл хамааран хавдрын эмчилгээнүүдийн улмаас биед үүссэн эдгэршгүй өөрчлөлтүүд (индурац, түр хугацаанд болон насан туршид тавигдсан цоргууд, мөч тайрагдсан байдал)<br>(Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь нь хорт хавдрын үе шатаас хамаарна) | | | 50-100 | Хугацаагүй | |

Энэхүү жагсаалтаар Мэргэжлээс шалтгаалсан өвчин болон Хурц хордлогын улмаас хөдөлмөрийн чадвар алдсан даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдалтыг магадлан шийдвэрлэх ба алслагдсан аймгийн болон гадаад оронд эмчлүүлэх шаардлагатай зэрэг шалтгаанаар хүсэлт гаргасан даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдалтыг 2 жилээр сунгаж болно.

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ ТБАГУУТГ
ХУУЛБАР ҮНЭН
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА
Гарын үсэг:
2023 он 11 сарын 08 өдөр